



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 168

Улаанбаатар хот

□ Б.Наран-Идэрийг ажилд томилох тухай □

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 19 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 52 дугаар тогтоол, Авлигатай тэмцэх газрын 2022 оны “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай” 05/4894 дүгээр албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Биеийн тамир, спортын улсын хорооны 2022 оны 1/187 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлаар Батмөнхийн Наран-Идэрийг 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн томилсугай.

2.“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Наран-Идэрийн ажлыг хүлээлцүүлэхийг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

3.“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Наран-Идэртэй Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132002486